

Гүйцэтгэлийн үнэлгээний бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Цагаан-Өвгөн Бумангэрэл

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах							
1	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмыг шинэчлэн батлуулна.	Сайдын тушаал, журам	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/115 дугаар тушаал	Журмын төслийг боловсруулж, батлуулсан байна.	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмын төсөлд оруулах өөрчлөлтийн саналын гол үзүүлэлт болох цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн туршилтын үр дүнг нэгтгэн саналаа ХНХЯ-нд /Засгийн газрын 5-р тогтоолд нэмэлт, өөрчлөлт / Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/992 дугаар албан бичгээр хүргүүлсэн.ХНХЯ-наас Засгийн газрын хуралдаанд уг тогтоолын өөрчлөлтийг оруулахад бэлэн болсон. Хүргүүлсэн саналын дагуу "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмын төсөл"-	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал:

					ийг боловсруулан бэлэн болгосон. Хавсралт: 4 файл		100%
2	Боловсролын чанарын баталгаажуулалт хийх журам, аргачлалын төслийг боловсруулна.	Төсөл боловсруулалтын хувь	-	Төсөл боловсруулалтын хувь 30%	Боловсролын чанарын баталгаажуулалт хийхтэй холбоотой холбогдох материалуудыг уншиж судалж, журмын төслийн эхийг боловсруулж байна.	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
3	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чанарын үнэлгээний журам"-ыг батлуулна.	Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.6 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3, 26.4, 26.5, 27 дугаар зүйлийн 27.7	-	100%	Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль тус тус батлагдсантай холбогдуулан Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.6 дахь хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3, 26.4, 26.5, 27 дугаар зүйлийн 27.7 дахь заалтыг тус тус заасныг үндэслэн энэхүү журмын төслийг боловсруулан БЕГ, БҮТ, мэргэжлийн байгууллагуудаас санал авч байна. Хавсралт: 1 файл	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 60% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

							байдал: 50%
4	Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журам	Журмын төсөл боловсруулалтын хувь	БСШУССайдын 2019 оны А/803 тушаал	Журмыг боловсруулж батлуулсан байна.	Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ хийх журмыг Боловсролын сайдын 2025 оны 01 сарын 29-ний өдрийн А/37 дугаар тушаалаар батлуулан, Боловсролын ерөнхий газар болон Боловсролын үнэлгээний төвд журмын хэрэгжилтийг хангах албан бичиг хүргүүлэв. Хавсралт: 3 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
5	Элсэлтийн шалгалтын журамд нэмэлт, өөрчлөлт оруулна.	Журам боловсруулалтын хувь	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/66 дугаар тушаал	Сайдын тушаалаар журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.22 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дугаартай албан даалгаврын 16.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.22 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 18.3 дахь заалтыг тус тус үндэслэн, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дугаартай албан	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

					даалгаврын 16.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Журам батлах тухай” А/66 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Элсэлтийн шалгалт зохион байгуулах журам”-д нэмэлт өөрчлөлтийг Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/69 дүгээр тушаалаар батлуулан Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэв. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089468540001 Хавсралт: 1 файл		байдал: 100%
6	Боловсролын үндэсний үнэлгээ зохион байгуулах ажлыг удирдлага, зохицуулалтыг хангана.	Гүйцэтгэлийн үнэлгээ, элсэлтийн шалгалт, сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, чанарын үнэлгээ зохион байгуулахтай холбоотой сайдын тушаал, чиглэл	МУЗГ-ын 2024 оны 25 дугаар тогтоол, БШУСайдын А/115 дугаар тушаал,	70%	1 . "Монгол хэл бичгийн шалгалт"-ын бэлтгэл хангах, зохион байгуулах тухай асуудлаар Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 02 дугаар албан даалгаврыг боловсруулж, батлуулав. 2 . Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг 2025.04.28-05.03-ны өдрүүдэд, Ерөнхий боловсролын сургалтын байгууллага, багшийн гүйцэтгэлийн үнэлгээ 2025.05.12-23-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахтай холбогдуулан "Боловсролын сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах тухай " Боловсролын сайдын 03 дугаар албан даалгаврыг боловсруулж батлуулав. 3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахад шаардагдах зардлыг /2,015,861,328 төгрөг/ Боловсролын сайдын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/117 дугаар тушаалаар батлуулав. 4. "Монгол хэл бичгийн шалгалт"-ын бэлтгэл хангах, зохион байгуулах тухай Боловсролын сайдын 02 дугаар албан даалгаврыг боловсруулан, 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр батлуулав. 4. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Журам батлах тухай" 2024 оны 115 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журам"-ын дагуу СӨБ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ 2025 оны 4-р сарын 28-наас 5-р сарын 5-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 995 цэцэрлэг, 7290 багш, ЕБС-ийн гүйцэтгэлийн үнэлгээ 2025 оны 5-р сарын 12-23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 700 сургууль, 29689 багш хамрагдлаа. 5. Боловсролын сайдын 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн "Элсэлтийн болон монгол, хэл бичгийн шалгалт зохион байгуулах зардал батлах тухай " А/102 дугаар тушаалаар / 1,427,057,400/ зардлыг батлуулав. Хавсралт: 3 файл		
7	Монгол бичгийн цахим систем нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	GOOGLE хамтран монгол бичгийн цахим систем хөгжүүлэлтийн хувь	Болор софт ХХК Чимэгэ хөрвүүлгийн программ	40%	Төрийн албан хаагчдад зориулсан монгол бичиг сурах гар утасны аппликэйшнийг хөгжүүлэх ажлыг ВИЭСЭМ ТЕК ХХК гүйцэтгэсэн. "Үндэсний бичиг" мобайл аппликэйшн нь монгол бичигт суралцах, мэдлэгээ бататгах, шалгалт өгөх боломжийг бүрдүүлсэн аппликэйшн юм. Уг платформ нь цахим сургалтын дэвшилтэт шийдлийг ашиглан хэрэглэгчдэд онлайнаар болон сүлжээгүй орчинд ч үр дүнтэй суралцах боломжийг олгож байгаа. Монгол бичгийн анхан болон ахисан түвшний хичээлүүдийг YouTube видео болон PDF форматаар	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

				оруулж, суралцагчид өргөн сонголттойгоор хичээлээ үзэх боломжтой. Цагаан толгой: Үсэг тус бүрийн зурлага бүхий дэлгэрэнгүй танилцуулга, үндсэн ойлголтуудыг зураг хэлбэрээр багтаасан. Тулгуур ойлголт: Монгол бичгийн хичээлүүдийг зурган хэлбэрээр үзэх боломжтой. Сорил: 800 гаруй сорилыг агуулсан, хэрэглэгч тус бүрийн мэдлэгийг үнэлэх шалгалтын модуль. Үр дүнг бодитоор тооцон тайлагнах боломжтой. Хэрэглэгчийн бүртгэл ба статистик: Хэрэглэгч бүрийн сорилын гүйцэтгэл, нас, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэргийг ангилан харах дэвшилтэт шүүлтүүр бүхий тайлангийн хэсэгтэй. Вэб суурьт удирдлагын хэсэг нь PHP 8.3 болон Laravel framework дээр хөгжүүлэгдсэн. Админ нь хичээл, сорил, хэрэглэгчийн мэдээлэл болон аппликэйшний бүх контентийг хялбар удирдах боломжтой. Аппликейшн хөгжүүлэлт хийгдсэн: Мобайл хувилбар Flutter 3.32 хувилбар дээр шинэчлэн хөгжүүлэлт хийгдсэн. Android болон IOS бүх төхөөрөмжүүдийг дэмжиж ажиллахаар хийгдсэн байна. Мэдээлэл оруулах тест хийх ажлууд хийгдэн цагаан толгойн зурлага: 291, Тулгуур ойлголт: 100, Хичээл: 20, Сорил: 896 үндсэн мэдээлэл оруулсан байна. Сүлжээгүй орчинд ажиллах шийдэл нь нэлээдгүй бэрхшээлтэй байсан. Мөн Google PlayStore болон Apple AppStore байршуулах үед өмнөх ашиглаж байсан түлхүүр үг байхгүй улмаас оруулах үед хугацаа алдаж байна. Удирдлага хэсэг шинээр хийгдэн аппликэйшн онлайн болон оффлайн ажиллах боломжтой болсон байгаа мөн хэрэглэгчээр бүртгүүлж сорилын үр дүнг харах, удирдлага хэсгээс мэдээлэл оруулахад хялбар бүрэн динамик болгон	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--

					өөрчилсөн.		
8	Боловсролын бодлого төлөвлөлтийн чиглэлээр орон нутгийн Боловсролын газрын хүний нөөцийн чадавхыг сайжруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ	Арга зүйн дэмжлэг үзүүлсэн Боловсролын газрын эзлэх хувь	-	60	1. 2025.04.27-30-ны өдрүүдэд Орхон, Булган аймгийн Боловсролын газрын албан хаагч нарт болон боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтнуудад боловсролын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэв. Энэхүү ажлын хүрээнд: Боловсролын сайд, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр түүнд туссан боловсролын салбарын бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт, Орхон, Булган аймгийн Боловсролын газар, зарим сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцаж, Цэцэрлэгийн багшийн ажлын болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний зохион байгуулалтын явцтай танилцав. 2. Баруун бүсийн зөвлөгөөн зохион байгуулахтай холбогдуулан Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Боловсролын газруудаас зөвлөгөөнтэй холбоотой ажлын мэдээллүүд авч, танилцуулгыг бэлтгэн хамтран ажиллаж, арга зүйн зөвлөгөө өгөв.	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам-д нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, ХНХЯ-нд хүргүүлнэ.	Тогтоолын төсөлд тусгах санал	Засгийн газрын 2019 оны 5-р тогтоол	Тогтоолын төсөлд тусгах саналыг боловсруулж, холбогдох яаманд хүргүүлсэн байна.	Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөлд тусгуулах саналаа боловсруулан ХНХЯ-нд 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/992 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу Засгийн газрын хуралдааны 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр товлөгдсон боловч Засгийн газрын 25-р тогтоолын өөрчлөлттэй хамтатган оруулахаар хойшлогдсон.	3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

					Хавсралт: 3 файл		үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1 0	Засгийн газрын 2024 оны 25-р тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулна.	Тогтоолд өөрчлөлт оруулах санал боловсруулсан байдал	Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн "Журам батлах тухай" 25-р тогтоол	Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсгийг үндэслэн Засгийн газрын 2024 оны 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоол болон мөн тогтоолын хавсралтаар батлагдсан "Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч нэгтгэв. Хавсралт: 17 файл	3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1 1	Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай зөвлөмж боловсруулна.	Зөвлөмж	-	Зөвлөмжийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.	1."Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" -ийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, танилцуулгыг боловсруулж Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1/104 дүгээр албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүрүүлсэн. 2. Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл гарч, энэхүү тэмдэглэлээр Монгол хэлний тухай хуулийн 7.2-т заасны	1-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын

					дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах болсон тул уг асуудлаар холбогдох байгууллагуудад "Зөвлөмж" хүргүүлж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Боловсролын сайдад, зөвлөмжийн дагуу зохих арга хэмжээ авч ажиллахыг ЗГ-ын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосон. 3. Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/377 дугаар албан бичгээр "Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх тухай зөвлөмж"-ийг боловсруулан ЗГ-ын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт хүргүүлэв. Хавсралт: 3 файл		үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1.3. Боловсролын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хуулийн төсөл боловсруулах, батлуулах, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл боловсруулах, салбар хоорондын уялдааг бодлогын удирдамжаар хангах, боловсролын чанарын үнэлгээ болон насан туршдаа суралцахуйн тогтолцоог хөгжүүлж бүх түвшний боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын чиглэл боловсруулах							
1 2	Олон улсын сурлагын амжилтын судалгааг зохион байгуулах бэлтгэлийг хангаж, судалгааны ажлыг удирдлага, зохицуулалтаа	PISA-2025 үнэлгээний үндсэн судалгаанд хамрагдсан суралцагчийн хувь (192 сургуулийн 7450 суралцагч) ЭЗХХАБ-ын International Early Learning	PISA-2022	50	1. " Олон улсын "PISA-2025" үнэлгээний бэлтгэл хангах, зохион байгуулах тухай " Боловсролын сайдын 01 тоот албан даалгаврыг боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулав. 2. " Олон улсын суралцагчийн сурлагын амжилтын "PISA-2025" үнэлгээний үндсэн судалгаанд хамрагдах зардлын тооцоог хийж, тушаалын төслийг боловсруулж " Олон улсын суралцагчийн сурлагын амжилтын "PISA-2025" үнэлгээний үндсэн судалгаанд хамрагдах зардал батлах тухай " Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр	1-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 60% Нэгжийн даргын үнэлгээ

	р хангана.	and Child Well-being Study-д хамрагдах талаар хийгдсэн судалгаа			сарын 29-ний өдрийн А/38 дугаар тушаалаар батлуулав. 3. Олон улсын "PISA-2025" үнэлгээнд Орон нутгийн 100, нийслэлийн 91 сургуулийн 7450 сурагч түүвэрт сонгогдон хамрагдахаас 7142 сурагч (ирц 96%) хамрагдаж, мөн тооны эцэг эх, 1329 багш (ирц 96%) асуулгад хамрагдлаа. Хавсралт: 3 файл		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
1 3	Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнана.	Биелэлтийн хувь	2024 оны гүйцэтгэлийн түвшингээр	100	Суурь боловсролын академик үгийн сангийн нөөцийг тогтоож, түвшинд оноох судалгааны ажилд шаардагдах зардлын тушаалыг төлөвлөн Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/227 дугаар тушаалаар батлуулав. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн , дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Боловсролын асуудлаар гарч буй судалгааны ажил, өгүүллэг уншиж мэдлэгээ дээшлүүлнэ.	Уншиж судалсан ном, гарын авлага, тайлан, судалгаа (тоогоор)	2024 оны хүрсэн түвшин	5-аас доошгүй	Боловсролын чанарын баталгаажуулалт болон үнэлгээний чиглэлээр хийгдсэн судалгаа, баримт бичиг, тайлангуудыг уншиж судлав. Хавсралт: 8 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Эрхлэх асуудалд хамаарах шинээр батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг судлан, сан үүсгэнэ.	Судалсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр (тоогоор)	2024 оны хүрсэн түвшин	5-аас доошгүй	Эрхлэх асуудалд хамаарах 2024-2025 онд шинээр болон шинэчлэн батлагдсан Засгийн газрын тогтоол, сайдын тушаал шийдвэрийг судлан сан үүсгэсэн. Хавсралт: 21 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
3	Үндэсний бичгийн мэдлэг, чадвараа	Албан хэргийг хос бичгээр	2024 оны хүрсэн түвшин	өмнөх түвшингээс ахисан байна.	1. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд Боловсролын сайдын "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хэрэгжилт болон төрийн албан	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар,	Өөрийн үнэлгээ: 100%

	дээшлүүлсэн байна	хөтлөн явуулах чадварын түвшингэ э ахиулсан байдал	н		хэргийг хос бичгээр хөтлөх "Зөвлөмж"-ийн талаар танилцуулж, уг хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр "Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх зөвлөмж"-ийг боловсруулан Засгийн газрын гишүүд, аймаг нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгосон. Үүнтэй холбогдуулан уг зөвлөмжийг боловсруулан хүргүүлсэн. 2. Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх чадамжаа дээшлүүлсэн. Үндэсний бичиг аппликэйшнийг тогтмол ашигладаг. https://play.google.com/store/apps/details?id=com.edu.mn&hl=mn Хавсралт: 1 файл	5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11- р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100%
--	----------------------	--	---	--	--	--	---------------------------------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэлийн үнэлгээний бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч, Цагаан-Өвгөн Бумангэрэл /...../

Огноо: